



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2022 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/547

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 22 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 22 дугаар хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /П.Эрхэмбаяр/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/ -д тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.



141222624

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн А/547 дугаар тушаалын хавсралт

**МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС**

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн Дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Баянгол дүүрэг, Илаарших өрхийн эрүүл мэндийн төв	386/2022	2 жил	2022.11.13	2024.11.13
2.	Баянгол дүүрэг, Мэлмий хурц өрхийн эрүүл мэндийн төв	387/2022	2 жил	2022.11.13	2024.11.13
3.	Баянгол дүүрэг, Манай эмнэлэг өрхийн эрүүл мэндийн төв	388/2022	3 жил	2022.11.13	2025.11.13
4.	Чингэлтэй дүүрэг, Мэнд Арвижих өрхийн эрүүл мэндийн төв	389/2022	2 жил	2022.11.13	2024.11.13
5.	Сонгинохайрхан дүүрэг, Жаргал елзий өрхийн эрүүл мэндийн төв	390/2022	3 жил	2022.11.13	2025.11.13
6.	Сонгинохайрхан дүүрэг, Одонт манал өрхийн эрүүл мэндийн төв	391/2022	3 жил	2022.11.13	2025.11.13
7.	Сонгинохайрхан дүүрэг, Арвин мэнд өрхийн эрүүл мэндийн төв	392/2022	3 жил	2022.11.13	2025.11.13
8.	Сонгинохайрхан дүүрэг, Гурван тэрх өрхийн эрүүл мэндийн төв	393/2022	3 жил	2022.11.13	2025.11.13
9.	Сонгинохайрхан дүүрэг, Алтан цэгцүүхэй өрхийн эрүүл мэндийн төв	394/2022	2 жил	2022.12.24	2024.12.24

оо0оо